

## ГАРЧИГ

Оршил.....	2
I Төслийн танилцуулга.....	3
II Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга	8
III Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	9
IV Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	11
V Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.....	13
V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	15
V.3 Тэрбум мод төслийн хүрээнд.....	15
V.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .	16
V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	16
V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	16
V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	17
V.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	17
V.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	19
V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	20
V.11 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	20
V.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .....	21
Дүгнэлт.....	22
Ашигласан хэвлэл .....	23

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	3
Хүснэгт 2. Уурхайн солбилцол .....	3
Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим .....	6
Хүснэгт 4. Ил уурхайн ажлын горим 2 дахь жил.....	6
Хүснэгт 5. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл.....	6
Хүснэгт 6. Шимт хөрс хуулалт .....	7
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	13
Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	15
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн талбайн солбилцол .....	15
Хүснэгт 10. Мод тарьж ургуулах.....	16
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	16
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	18
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	20
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	21
Хүснэгт 16. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь .....	22
Хүснэгт 17. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал.....	23

## ОРШИЛ

---

“Эм Эс бэл майнинг” ХХК-ийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ–нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 17,152,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

## I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**Төлөвлөгөөний нэр:** Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших 40.64 га талбайг хамарсан Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** “Эм Эс бэл майнинг” ХХК

### Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

№	Үзүүлэлтүүд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	
2	Улсын бүртгэлийн дугаар	
3	Уурхайн нэр	
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг
5		Сум/Дүүрэг
6	Ашигт малтмалын төрөл	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	
8	Ашиглалт эхэлсэн огноо	
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот
10		Сум/Дүүрэг
11		Баг/Хороо
12		Гудамж/Байр
13	Гар утас	
14	Захирлын хаяг	Нэр
15		Гар утас
16		Электрон шуудан

**Төслийн байршил:** “Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон орд нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 449 км, Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумаас баруун хойш 22 км зайтай байрлана.

- Засаг захиргаа: Өвөрхангай аймаг, Зүүнбаян-Улаан сум
- Ордын нэр: "Өртөнтийн урд дэнжийн хэсэг"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Алтны үүсмэл болон шороон орд
- Трапецийн номенклатур: L-48-49
- Талбайн нийт хэмжээ: 40.64 га

### Хүснэгт 2. Уурхайн солбилцол

№	Газарзүйн солбилцол			Уртраг		
	Өргөрөг			Уртраг		
1	46	37	39.36	102	23	15.23
2	46	37	39.44	102	23	18.88
3	46	37	52.23	102	23	18.28
4	46	37	52.39	102	23	25.56
5	46	37	58.86	102	23	25.24
6	46	37	58.87	102	23	26.17
7	46	37	14.92	102	23	25.4
8	46	37	14.03	102	23	23.9
9	46	37	6.93	102	23	21.09
10	46	37	5.24	102	23	21.17
11	46	37	5.23	102	23	20.42
12	46	37	59.51	102	23	18.16
13	46	37	58.7	102	23	18.2

№	Газарзүйн солбицол					
	Өргөрөг			Уртраг		
14	46	37	58.68	102	23	17.83
15	46	37	22.43	102	23	3.48
16	46	37	16.85	102	23	3.76
17	46	37	16.81	102	23	3.97
18	46	37	16.76	102	23	4.21
19	46	37	16.74	102	23	4.33
20	46	37	16.6	102	23	4.91
21	46	37	16.56	102	23	5.08
22	46	37	16.5	102	23	5.28
23	46	37	16.38	102	23	5.68
24	46	37	16.2	102	23	6.23
25	46	37	16.17	102	23	6.3
26	46	37	16.1	102	23	6.48
27	46	37	15.92	102	23	6.94
28	46	37	15.68	102	23	7.45
29	46	37	15.62	102	23	7.59
30	46	37	15.54	102	23	7.74
31	46	37	15.35	102	23	8.1
32	46	37	15.07	102	23	8.56
33	46	37	14.92	102	23	8.78
34	46	37	14.85	102	23	8.87
35	46	37	14.7	102	23	9.09
36	46	37	14.38	102	23	9.5
37	46	37	14.24	102	23	9.66
38	46	37	14.16	102	23	9.75
39	46	37	13.97	102	23	9.96
40	46	37	13.61	102	23	10.31
41	46	37	13.58	102	23	10.33
42	46	37	13.48	102	23	10.42
43	46	37	13.19	102	23	10.67
44	46	37	13.68	102	23	32.12
45	46	37	20.15	102	23	31.8
46	46	37	20.04	102	23	27.11
47	46	37	23.28	102	23	26.96
48	46	37	23.2	102	23	23.43
49	46	37	26.45	102	23	23.03
50	46	37	26.42	102	23	16.08



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

**Орд ашиглах тусгай зөвшөөрөл:** Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт” нэртэй 40.64 га талбай бүхий ашигт малтмалын MV-000436 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гурван тамга” ХХК-д 30 жилийн хугацаатай олгосон байна.

Улмаар 2020 оны 05 дугаар сарын 27–ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 174 тоот тушаалаар “Ирмүүн босго” ХХК-иас 2020 оны 05 дугаар сарын 27–ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 174 тоот тушаалаар “Цариг шонхор” ХХК-нд шилжүүлсэн байна. 2022 оны 11 дугаар сарын 25–ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 95 тоот тушаалаар “Эм эс бэл майнинг” ХХК-нд шилжүүлсэн байна.

**Ашиглалтын системийн сонголт:** Ордыг ил аргаар ашиглана.

**Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц:** Өртөнтийн үүсмэл ордын хэсгийн С-3, С-2, блокууд урд болон хажуу талаараа тусгай зөвшөөрлийн хилд тулсан байгаа нь уурхайн хажуу хананд батлагдсан нөөцөөс зайлшгүй хаягдал үүсэх нөхцлийг бүрдүүлж байна. Уурхайн эцсийн хүрээ хязгаарыг тодорхойлон ашиглалтын нөөцийг тооцоход нийт нөөцөөс 3.16 мян.м<sup>3</sup> элс /0.33 кг металл хими цэвэр/ ил уурхайн хүрээ хязгаарын гадна хаягдан уурхайн хүрээ хязгаарт В+С зэрэглэлээр 119.69 мян.м<sup>3</sup> элс /12.37 кг алт хими цэвэр/ ил уурхайн хүрээ хязгаараар хязгаарлагдан хаягдана.

**Төслийн хүчин чадал:** Ил уурхайн жил бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба эхний жилд 60.13 мян.м<sup>3</sup>, 2 дахь жилд 72.75 мян.м<sup>3</sup> элс олборлоно. Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын нөөцийг 2 жилийн хугацаанд олборлоно. [Төслийн ТЭЗҮ, 2023 он]

**Уурхайн ажлын горим:** Уурхайн олборлолт хөрс хуулалтын үйл ажиллагаа нь тухайн жилийн II-р улирлаас III-р улиралын хооронд дулааны улиралд явагдах бөгөөд техникийн даалгаврын дагуу 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Угаан баяжуулах хэсэг нь 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
2	Бүтээлтэй ажиллах хугацаа	цаг	11
3	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	1
4	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	51
5	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	51
6	Жилийн ажлын цагийн хэмжээ	цаг/жил	408
7	Цаг ашиглалт	%	92
8	Жилд ажиллах бодит цаг	цаг	375.36

Хүснэгт 4. Ил уурхайн ажлын горим 2 дахь жил

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
2	Бүтээлтэй ажиллах хугацаа	цаг	11
3	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	1
4	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	62
5	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	62
6	Жилийн ажлын цагийн хэмжээ	цаг/жил	496
7	Цаг ашиглалт	%	92
8	Жилд ажиллах бодит цаг	цаг	456.32

**Ашиглалтын технологи.** Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын хөрсний зузаан нь таазны бохирдол хасаж тооцсоноор дунджаар 2 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулан овоолно.

Ордын элс нь хэвтээ ойролцоогоор 30 уналтай, нөөцийн блокуудын өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийж ашиглах ба ордын ашиглалтанд ил аргаар авто тээвэртэй гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Хүснэгт 5. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Ил аргаар авто тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Экскавац
	2. Олборлолт	2.1. Ухаж ачих
		2.2. Тээвэрлэх
		2.3. Овоолох (агуулахад хураах)

**Шимт хөрс хуулалт:** Шимт хөрсийг САТ D-8 маркийн бульдозероор түрж шимт хөрсний овоолгод овоолно. Шимт хөрсний овоолгыг 350 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбайгаас 0.2 метр зузаантайгаар 14.41 мян.м<sup>3</sup> /сийрэгжээгүйгээр/ шимт хөрс хуулж овоолно.

Хүснэгт 6. Шимт хөрс хуулалт

Ашиглалтын жилүүд	Шимт хөрс хуулалт, мян.м <sup>3</sup>	
	Уурхайн талбай	Нийт
1 дэх жил	9.94	9.94
2 дахь жил	4.47	4.47
<b>Нийт</b>	<b>14.41</b>	<b>14.41</b>



## II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Газарзүйн нөхцөл:** Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан нь Монгол Улсын хөгжлийн бүсчлэлээр төвийн бүсэд багтаж физик газарзүйн бүсчлэлээр Хангай Хэнтийн уулархаг мужид хамаарна. Зүүнбаян-Улаанын газар нутгийн хэмжээ 74000м<sup>2</sup> хавтгай дөрвөлжин талбайтай. Хэнтийн нурууны баруун урд шувтрагын нам өндөртэй бөмбөгөр оройтой уулсын дунд засаг захиргааны хувьд хойд талаараа Эрдэнэ сумтай зүүн урд талаараа Баян сумтай урд талаараа Баянцагаан сумтай баруун талаараа Алтанбулаг зэрэг сумтай хиллэн оршино.

**Уур амьсгал:** Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын жилийн дундаж хур тунадасны мэдээллийг хамгийн ойр хил залгаа орших Арвайхээрийн хотын станцаас авч үзэхэд олон жилийн дундажыг тооцоолохын тулд хамгийн их хур тунадас ордог 5-9 сарын жилийн дундаж хур тунадасны хэмжээ 48.33 мм байна. Харин 5-9 сарын хур тунадасны мэдээллээс хамгийн их үзүүлэлттэй буюу 100-аас дээш үзүүлэлттэй мэдээлэлийг хасаж авч үзэхэд хур тунадасны жилийн дундаж нь 32.6 мм байна.

**Усан орчин:** Төслийн талбай нь Хойд мөсөн далайн ай савын бөгөөд түр зуурын элбэг тэжээлтэй, Хэнтийн дэд мужийн Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт харьяалагдана. Төслийн талбайд гадаргын ус байхгүй байна. Төслийн талбайд өөрийн эзэмшлийн 4 гүний худагтай бөгөөд нийт усны хэрэглээгээ хангаж ажиллана.

**Хөрс, ургамал:** Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаанын нутаг дэвсгэрт орших “Бор тал” нэртэй алтны шороон орд нь газрын гадаргын хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулын мужийн Туулын дэд мужид харьяалагдана. Төсөл хэрэгжих талбай нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын холимог бүсчлэл бүхий Хангайн мужийн өндрийн бүсчлэлийн хэв шинж бүхий өмнөд Хэнтийн 52-р тойрогт багтана. Тухайн бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евроазийн тал хээрийн мужид хамаарна. Монгол орны хээрийн бүс нутгийг илтгэх Хялганат хээр тохиолдоно.

**Амьтны аймаг:** Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Дундад Халхын тойрогт тал хээрийн бүсэд хамаарна. Тус уурхайд өмнө нь олборлолт явуулж байсан учраас амьтад үргэн дайжсан байна.

Тус суманд амьтны аймгаас нийтлэг буюу зөвхөн тал хээрийн нөхцөлд дасан зохицсон амьтад тохиолдоно. Үүнд: туулай хэлбэртнээс бор туулай, огодой, мэрэгчдээс үлийн цагаан оготоно, махан идэштнээс саарал чоно, хярс, үнэг, шувуудаас шоорон эвэрт болжмор, монгол болжмор, шилийн сар, хөхтөн амьтнаас цагаан зээр зэрэг амьтад элбэг таардаг. Энэхүү бүс нутагт тохиолдох 6 баг, 17 овог, 40 төрөлд хамаарах 54 зүйл хөхтөн амьтан байдаг.

**Нийгэм, эдийн засаг:** Засаг захиргааны төвүүд нь Улаанбаатар хоттой засмал болон шороон замаар холбогдсон. Утсан харилцаа сайн хөгжсөн. Өндөр хүчдэлийн шугам, төмөр замтай. Ордын орчим гадаргын ус байхгүй, хур тунадас ихтэй үед зарим хөндийд үерийн ус түрж урсаж байдаг. Нийгэм эдийн засгийн хувьд тус сум нийт 2067 хүн амтай, хүн амын нягтаршил 0.5, өрхийн тоо 815 байна.

### Ш ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Уурхайд ачих, зөөж тээвэрлэх, боловсруулах тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалттайгаар засварын жижиг хэсэг ажиллана. Эдгээр үйл ажиллагааны явцад алтны үүсмэл шороон ордын газрын гадарга, хэвлий нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхөөр байна,

#### **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

- Агаарын бохирдол /уурхайн малталт, овоолгууд, тээвэрлэлтийн зам болон хөрс хуулалт зэрэг технологи ажиллагаанаас тоос дэгдэнэ/,
- Тээврийн хэрэгслийн шаталтат хөдөлгүүрээс ялгарах утаа тортогоос үүсэх бохирдлын нөлөө,
- Түр суурьшлын бүсэд хог хаягдал, шатах тослох материалын үнэр хүрээлэн буй орчинд тархана,
- Үйлдвэрлэлийн дотоод тээврийн замын нөлөөгөөр хөрсний бүтэц алдагдсанаас нарийн ширхэгтэй тоос агаарт дэгдэж тэр хэмжээгээр орчны газрын хөрс, ургамлан нөмрөгийг доройтолд оруулах.

#### **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

- Төслөөс гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй байна,
- Төслийн технологийн хэрэгцээнд хэрэглэх усыг газрын доорх усаас авч ашиглах учир гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсэх,
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал уурхайн орчинд тархаснаас хөрсийг бохирдуулснаас гүний усыг бохирдуулах,
- Тунаах нуурын далангийн суурийн бат бөх байдал, далан сэтэрч болзошгүй.

#### **Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

- Хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтол эрчимжинэ,
- Уурхайн дотоод тээврээр хөрс, ургамал талхлагдана,
- Уурхайд олон салаа шороон зам үүссэнээс хөрсний элэгдэл эвдрэл үүсэх,
- Шатах тослох материалын ашиглалт, хадгалалтаас үүдэлтэй хөрсний бохирдол хязгаарлагдмал орчинд үүснэ,
- Түр суурьшлаас эх үүсвэртэй хог хаягдлаар хөрс бохирдох,
- Тунгаах нуурын шаланд тунасан лаг орчныг хөрсийг бохирдуулах.

#### **Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:**

- “Өртөнтийн урд дэнжийн хэсэг” -ын алтны шороон ордын үйл ажиллагаа явагдаад олон жил болж байгаа учир олон салаа зам гаргах, ус цуглуулах зорилгоор татсан шуудуу, газрын эвдрэлээс шалтгаалсан доройтол олборлох үйл ажиллагаа явагдсан хэсгээр байна. Цаашид ашиглалтын талбай нэмэгдэхийн хирээр ургамалд үзүүлэх сөрөг нөлөөний цар хүрээ тэлэх боловч нөлөөллийн эрчим өсөхгүй,
- Уулын ажлын үед тээвэрлэлт, түр зам ашиглалт, орчны газар ашиглалт, тоосжилтоос ургамлын ургах орчин доройтох.

#### **Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:**



- Төслийн үйл ажиллагаа, машин техник, тоног төхөөрөмжийн дуу чимээ, хөдөлгөөнөөс амьтад дайжин амьдрах орчин өөрчлөгдөх,
- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

**Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

- Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй,
- Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно,
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ,
- Улс орны төсөвт мөнгөн хуримтлал бий болгоно,
- Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.

#### IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:** Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

**БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл:** Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

**БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга:** Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

#### **Байгаль хамгаалах төлөвлөгөө:**

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

#### **Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:**

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

**БОМТ-ний бүтэц:** БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт

## V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
<b>Агаарын чанар</b>							
1	Агаарын бохирдлын эх үүсвэрүүд: Ил уурхай, уурхайн тээврийн зам, овоолго үүсгэх үйл ажиллагаа, хогийн цэг	Олборлолтын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж тогтмол усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Тээврийн зам	-	Усны төлбөрт орсон	Тогтмол	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль,
2		Зам арчилгааны зардал	Тэврийн зам	төг	500,000.0	Жил бүр	
3		Агаарын тоосны (TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн ойр орчим		ОХШХ-г тусгагдсан	Жилд 2 удаа	
4		Тээврийн хэрэгсэл хүнд даацын машины хурдыг тогтмолжуулах журам гаргаж мөрдүүлэх, машин техникийн үзлэг шалгалтыг төлөвлөгөөт хугацааны дагуу тогтмолжуулж, байгаль орчинд сөрөг нөлөөтэй, угаа, хорт хий ихээр ялгаруулах техникийн шаардлага хангахгүйг сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологээр шинэчилж, аюулгүй ажиллагааг хангах.	Хүнд машин, техникүүд	төг	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
5		Хог хаягдлын цэг болон бие засах газар түүний ойр орчимд тогтмол ариутгал хийж байх	Хог хаягдлын цэг	төг	150,000.0	Жилд 2 удаа	
<b>Гадаргын ба газрын доорхи усны нөөц</b>							
6	Үүний усны нөөцөд нөлөөлөх эсэх. Хөрсний усыг бохирдуулахгүй байх	Усыг хэмнэлттэй ашиглах, усыг дахин ашиглах	-	-	Дотоод зардал	Үйл ажиллагааны туршид	-Ус ашигласны төлбөр (2013 оны-327 → тогтоол ) -Усны тухай хууль, “Газар доорх усыг бохирдлоос амгаалах” MNS 3342:1982
7	Хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах.	-	төг	200,000.0	Жил болгон /эвдэрсэн тохиолдолд засварлана/	“Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага” MNS5916 :2008

8	Шатах тослох материалаар дамжин ургамал, хөрсөн бүрхэвч бохирдох	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	ШТМ	-	Дотоод зардал	тогтмол	Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд: MNS3298-91, Хөрс-агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох: MNS3310-918, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ: MNS5850-2008
9	Машин техникийн засвар үйлчилгээ бусад үйл ажиллагаанаас хөрс бохирдуулах	Засвар үйлчилгээ хийхэд хөрсийг нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх нөхцөл бүрдүүлэх бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж шинэ хөрсөөр сэлбэх	-	-	Дотоод зардал	Жил бүр	
10	Хөрсний бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх	Уулын ажлыг зөвхөн уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн талбайд	-	-	Тогтмол	
11	Уул уурхайн үйл ажиллагаанаас өнгөн хөрс эвдрэх, доройтох	Олборлолт дууссаны дараа байгаль орчны унаган төрхийг хэвээр хадгалж үлдэхийн тулд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгч байх	Уурхайн талбайд	-	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	
12		Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Уурхайн ухаш, овоолгын талбай	-	Дотоод зардал	Үйл ажиллагааны туршид	
13		Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах бохирдохоос хамгаалах урьдчилан сэргийлэх	Шимт хөрсний овоолго	-	Дотоод зардал	Уурхайн эхлэх үед	
<b>Ургамлан нөмрөг</b>							
13	Ургамлын биомассд нөлөөлөх эсэх	Тоос үүсэх талбайг услах	Уурхайн зам		Усалгааны зардалд орсон	Байнга	2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ургамал хамгааллын тухай 1995 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн байгалийн ургамлын тухай хууль
<b>Усны нөөц, чанар</b>							
14	-Ундны усыг зориулалтын саванд хадгалаагүйгээс ус бохирдох, хүний биед муугаар нөлөөлөх, -Бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх.	Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх, орчны бохирдол үүсэхээс сэргийлж хуримтлуулах, тогтмол зайлуулах	Бохир ус		Дотоод зардал	Үйл ажиллагааны явцад тогтмол	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль /Ерөнхий сайдын захирамжийг мөрдлөг болгох / -Ус ашигласны төлбөр (2009 оны 351р тогтоол)
15		Шатах тослох материал алдагдах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	ШТМ		Дотоод зардал	Тогтмол	
<b>Нийт</b>				<b>төг</b>	<b>850,000.0</b>		

## V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь “Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл шороон ордын 2024 онд өөрийн ашигласан 2.5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн хийхээр төлөвлөөд байна. Ингэхдээ ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх ба ашиглалт дууссаны дараа тухайн талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөөд байна.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	6	7	8	
1.	Техникийн нөхөн сэргээлт	Ашигласан талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх	га	2.5	Үйл ажиллагааны зардал	2024 онд	MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
2.	Биологийн нөхөн сэргээлт	Ашигласан талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх	га	2.5	3,000,000.0	2024 онд	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага MNS 4919:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
<b>Нийт</b>					<b>3,000,000.0</b>		

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн талбайн солбицол

№	Газарзүйн солбицол				Уртраг		
	Өргөрөг			Уртраг			
1	46	37	19.65	102	23	3.62	
2	46	37	19.71	102	23	10.76	
3	46	37	17.97	102	23	10.85	
4	46	37	17.05	102	23	14.51	
5	46	37	13.17	102	23	10.65	
6	46	37	15.09	102	23	8.49	
7	46	37	16.83	102	23	3.75	



### V.3 Тэрбум мод төслийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигт зааснаар тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эм Эс бэл майнинг” ХХК-д аймгийн БОАЖГ-тай зөвшилцөн санал болгосон газарт 200 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийхээр тусгаж өгсөн. Төсөл хэрэгжүүлэгчтэй ярилцан хайлаас, улиас, бургас, үхрийн нүд тарьж ургуулахаар тусгасан ба 1 наст суулгацаар тарина гэж тооцов. Зардалд суулгацын үнэ, тээврийн зардал, тарих зардал, усалгаа тордлогооны зардлыг тооцсон, нийт суулгацын 70% нь ургана гэж тооцов.

Төсөл хэрэгжүүлэгч нь Зүүнбаян-Улаан сумын ЗД-тай мод тарих гэрээ байгуулан сумын 2024 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсан бөгөөд энэ ажлын хүрээнд сумын төвд буюу газарзүйн 46° 31’ 21”, 102° 35’ 46” солбилцолд 200ш модын тарьж ургуулна.

		<i>Хүснэгт 10. Мод тарьж ургуулах</i>	
№	Хийгдэх ажил	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
1	Бургас, Шар хуайс, Үхрийн нүд	200 ш	3,000,000.0
<b>Нийт</b>			<b>3,000,000.0</b>

### V.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

		<i>Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>						
№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	<i>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>			
					Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх ёстой байдаг.	Зүүнбаян-Улаан сумын нутаг дэвсгэрт байрлах Улаан дэл гэх газарт хууль бус гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухаж орхигдсон, эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	Зүүнбаян-Улаан сум, Улаан дэл нэртэй газар	га	5	5,000,000.0	2024 онд	МУ-ын хууль дүрэм журмын дагуу
<b>Нийт</b>						<b>5,000,000.0</b>		

### V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

### V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

## V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

"Эм эс бэл майнинг" ХХК -ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө			
			Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	5	6	7
1.	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Дотоод зардал	Үйл ажиллагааны туршид	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) - MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий ангилал
2.		Жил бүр мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	
3.		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	
4.		Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Тогтмол	
5.		Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жилд 1 удаа	
6.		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайд	600,000.0	2024 онд	
7.		Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	Уурхайн удирдлага	Дотоод зардал	Эвдэрсэн тохиолдолд засаж сайжруулах	
8.		Далан, хаягдлын санг үер усны үед хальж урсахаас урьдчилан сэргийлэх, байнга тогтворжуулж эвдрэл үүссэхээс урьдчилан сэргийлэх, хяналт мониторинг хийх	Уурхай орчимд	Дотоод зардал	Уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө	
<b>Нийт</b>				<b>600,000.0</b>		

## V.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Эдгээрт:

Уурхайн хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулж, хогийг ангилан ялгаж дахин ашиглах хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

Дахин ашиглагдах боломжтой хог хаягдлын ангилан ялгалтын хувь хэмжээг нэмэгдүүлж, уурхайн үйл ажиллагааны улмаас бий болсон дахин ашиглагдах хог хаягдлыг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг бий болгоно.

Хүснэгт 13.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	
1.	Ахуйн	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан гээвэрлүүлэх	Уурхайн талбай	450,000.0	Гэрээнд тусгагдсан	- Хог хаягдлын тухай хууль - Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS5924:2015
2.		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашааг тохижуулах		Дотоод зардал	Үйл ажиллагааны явцад тогтмол	
3.	Шингэн	Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS5924:2015 стандартын дагуу нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжийг байгуулах	Уурхайн ариун цэврийн байгууламж	Дотоод зардал	Ашиглалтын явцад	
4	Аюултай	2023 оны БОМТ-ний биелэлтийн тайланд тусгасны дагуу “Хай Би Ойл” ХХК-тай гэрээ байгуулан зайлуулах	Уурхайн талбай	Гэрээнд тусгагдсан	Гэрээнд тусгагдсан	
<b>Нийт</b>				<b>450,000.0</b>		

**V.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эм Эс бэл майнинг” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Уг ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ий тайлан, БОХТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Эм Эс бэл майнинг” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам)-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Хүснэгт 14.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
<b>Агаар</b>								
1.	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхай	Жилд 2 удаа	3 цэгээс дулаан улиралд 2 удаа	-	75,000.0	Цаг уур орчны шинжилгээний газрын байгаль орчны хэмжилзүйн төв лаборатори	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 0017-2-3-16:1988. Агаар мандал. Хот суурингийн агаарын бохирдлын шинжилгээ - MNS 5061:2001. Нүүрсхүчлийн хий. CO2 тодорхойлох эзлэхүүний арга
<b>Хөрс</b>								
2	Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC2.5 dS/m, P2O5, K2O, CaCO3)	Уурхайн карьерийн гадна талаас зонхилох салхины чиглэлийн дагуу	Жилд 2 удаа	-	20,000.0	40,000.0	ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. -MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
3	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Шатах тослох материалын агуулах, бохирдсон байж болох цэгүүдэс дээж авах	Жилд 1 удаа	-	45,000.0	45,000.0		
<b>Ус</b>								
4	Усны химийн шинжилгээ (pH, EC, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO3)	Ахуйн хэрэглээний уснаас	Жилд 2 удаа	-	46,000.0	92,000.0	ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	- MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга.
<b>Нийт</b>						<b>252,000.0</b>		

**V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

“Эм Эс бэл майнинг” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт ба аргачлал, тайлбар
	1	2	3	4	5	6
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Байнга	“Эм Эс бэл майнинг” ХХК	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
2.	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	“Эм Эс бэл майнинг” ХХК	
3.	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	“Эм Эс бэл майнинг” ХХК	
4	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Олон нийт	Дотоод зардал	Жил бүр	“Эм Эс бэл майнинг” ХХК	
5	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Ордод	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	4,000,000.0	“Эм Эс бэл майнинг” ХХК	
6	Газрын чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Ордод	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	5 жилд нэг удаа	“Эм Эс бэл майнинг” ХХК	
7	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Ордод	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	5 жилд нэг удаа	“Эм Эс бэл майнинг” ХХК	
8	Ажилчидыг хувцас хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Жил бүр	“Эм Эс бэл майнинг” ХХК	
<b>Нийт</b>				<b>4,000,000.0</b>		

**V.11 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

"Эм эс бэл майнинг" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 16. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
4.	Өвөрхангай аймаг, Зүүнбаян-Улаан сумын ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Эм Эс бэл майнинг” ХХК	Өвөрхангай аймийн Зүүнбаян-Улаан сум
5.	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Эм Эс бэл майнинг” ХХК	-
6.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТий хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Дотоод төлөвлөлтөөр	“Эм Эс бэл майнинг” ХХК	Засаг даргын тамгын газар



## V.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 17. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	850,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,000,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,000,000.0
4	Тэрбум мод төслийн хүрээнд	3,000,000.0
5	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	600,000.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	450,000.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	252,000.0
8	БОМТ-г хэрэгжүүлэх тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,000,000.0
9	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	Дотоод зардал
<b>Нийт</b>		<b>17,152,000.0</b>

“Эм Эс бэл майнинг” ХХК-ний “Өртөнтийн урд дэнж хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 17,152,000.0 төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

## ДҮГНЭЛТ

---

“Эм Эс бэл майнинг” ХХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

“Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 17,152,000 төгрөг гарахаар тооцоолсноос 50% –ийг нь Байгаль орчин, нөхөн сэргээх санд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

---

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол-1, 2023 он
7. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах ТЭЗҮ 2022 он
8. <http://www.legalinfo.mn>